



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/41

Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулж,
сургалтад хамруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.9 дэх заалт, Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журмын 3.27.1 дэх заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 4.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Монголын эрэлч нохой эзэмшигчдийн холбоо” НҮТББ-аас 2023 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 01-ний өдрийн хооронд зохион байгуулах “Нохой хөтлөгчийн давтан сургалт”-д Аюулгүй байдал, хамгаалалтын албаны нохой хөтлөгч шалгагч Д.Жаргал, Б.Баярбямба, хамгаалалтын ажилтан Т.Адъяа, Э.Ганбат, Ө.Энхмаа нарыг хамруулсугай.

2.Сургалтын төлбөр 2,000,000 (хоёр сая) төгрөгийг зохих журмын дагуу олгохыг Санхүү, эдийн засаг төлөвлөлтийн газар (Д.Пүрэв-Очир)-т зөвшөөрсүгэй.

3.Сургалтад хамрагдах ажилтнуудын ажлын цагт зохицуулалт хийж, сургалтын үйл явцад хяналт тавин, үр дүнг тооцож ажиллахыг Аюулгүй байдал, хамгаалалтын алба (Б.Сэр-Од)-нд үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн газар (Э.Нарантунгалаг)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ХАВСРАН
ГҮЙЦЭТГЭГЧ



Н.БАТСАЙХАН

1723 01 0342